



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 09

Эрдэнэт


“Ач санах” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 “е”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.4 заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Ач санах” хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөвт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ